



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

### Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаал, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбар тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн системд шилжсэнтэй холбогдуулан хүн амын өсөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөжүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шинэчилсэн дүрэм, бүтцийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Даваатөмөр)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны А/26, 2018 оны А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦЭНД-АЮУШ



1150500285



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн  
төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаал, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбар тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн системд шилжсэнтэй холбогдуулан хүн амын өсөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөжүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шинэчилсэн дүрэм, бүтцийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Даваатөмөр)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны А/26, 2018 оны А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦЭНД-АЮУШ



1150500265



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 05 дугаар сарын 24 -ний өдрийн  
1773 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Энэхүү дүрэм нь Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн Төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн байдлыг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Оршин байгаа хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо Утас/Факс: /976/70150056, E-mail: [bzdemt@gmail.com](mailto:bzdemt@gmail.com), Web site: [www.bzemn.ub.gov.mn](http://www.bzemn.ub.gov.mn)

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн Төв /цаашид “Төв” гэх/ нь хүн амын Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Нийслэлийн Эрүүл мэндийн газрын бодлого, чиглэл, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа, бие даасан төрийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2. Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэл, Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын шийдвэр, энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Эрүүл мэндийн төв нь нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, хүн амыг өвчин эмгэгээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэх, эрүүл аж төрөх нөхцөл, эрүүл мэндийн арга хэмжээнд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулах, нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалахаар гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн, Дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын өмнө үйл ажиллагааныхаа явц, үр дүнг тайлагнан, хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4. Эрүүл мэндийн төв нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.5. Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиниктэй нягт уялдаа холбоотой ажиллана.

### Хоёр. Эрхэм зорилго

2.1. Төвийн зорилго нь иргэдэд амьдралын зөв дадлыг олгох, хэвшүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх, хүн амын насжилтыг уртасгах, амьдралын чанарыг сайжруулахад оршино.

2.2. Төв нь алсын хараатай, эрхэм зорилго, зорилтонд тулгуурласан үйл ажиллагааг явуулах ба бэлэгдэл, тугтай байна.

### Төвийн бэлэгдэл



### Төвийн туг



Төвийн туг нь цэнхэр өнгөтэй, бэлгэдлийг тугны дунд хэсэгт байрлуулж, “Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв” гэж бэлгэдлийн дор голлуулж бичсэн байна.



## **Гурав. Үйл ажиллагаандаа баримтлах зарчим**

3.1. Төв нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

3.1.1. байгууллагын үнэ цэнэ, нэр хүндийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх;

3.1.2. иргэд үйлчлүүлэгч, өвчтөн болон хамтран ажиллах байгууллага, харилцагчдаа хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах;

3.1.3. хүнд суртал, авлигал, хээл хахууль, шан харамжаас ангид байх;

### **Дөрөв. Үндсэн чиг үүрэг**

4.1. Төв нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нийгэм, эдийн засаг, орчны хүчин зүйлийг судлан тогтоож, арилгах арга хэмжээ авах;

4.1.2. харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, оновчтой зохион байгуулж, өвчлөл, нас баралтыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах;

4.1.3. халдварт болон халдварт бус өвчин, хордлого, осол гэмтэл, нутагшмал болон мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх, өвчлөлийг бууруулах арга хэмжээ авах, энэ талаар тандалт судалгааг хийж, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг Дүүргийн хэмжээнд зохион байгуулах;

4.1.4. эмнэлгээс шалтгаалсан халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг харьяа салбар амбулаториудад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

4.1.5. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх;

4.1.6. харьяа нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс ажиллагсдынхаа эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх талаар зохиож байгаа ажилд нь хамтарч ажиллах, мэргэжил арга зүйгээр хангах, дэмжлэг;

4.1.7. ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах асуудлаар харьяа Салбар амбулатори, Зөвлөх Поликлиник, Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

4.1.8. салбар амбулатори, Зөвлөх Поликлиник, Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн Эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналт тавих, зөвлөн туслах, удирдлага арга зүйгээр ханга, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.1.9. эх, нярай, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржих, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ, эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.1.10. нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, өвчин үүсгэж буй хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх;

4.1.11. эмийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг Дүүргийн хэмжээнд зохион байгуулж, хүн амыг аюулгүй чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, хяналт тавих, мэдээлэх;

4.1.12. сувилахуйн тусламжтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, удирдлага арга зүйгээр хангах, биелэлтэд нь хяналт тавих, үр дүнг дүгнэх, сувилахуйн мэргэжилтнийг давтан сургах арга хэмжээг авч, тэдний мэдлэг, мэргэжил, ур чадвар, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.13. гамшиг, онцгой байдлын үед ажиллах харьяа салбар амбулатори, зөвлөх поликлиник, нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээ болон яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг дээшлүүлэх, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах;

4.1.14. эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулах, эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;



4.1.15. уламжлалт, нөхөн сэргээх анагаах ухаан, сувилалын тусламж, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

4.1.16. эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд үйлчлүүлэгч, иргэний нийгэм болон бусад хамтрагч талуудын оролцоог хангаж ажиллах;

4.1.17 хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийтийг хамарсан арга хэмжээнд нутаг дэвсгэрийн байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулах, хамтран ажиллах санал хүргүүлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

4.1.18. харьяа Салбар амбулатори, Зөвлөх Поликлиник, Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн статистикийн мэдээ, тайланг авч нэгтгэх, дүн шинжилгээ хийж, холбогдох дээд газруудад тайлагнах;

4.1.19. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх талаар төр засгаас баримталж байгаа бодлого, чиглэлд нийцүүлэн харьяа салбар амбулатори, зөвлөх поликлиник, нэгдсэн эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

4.1.20. эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дүүргийн хэмжээнд төлөвлөж, шаардлагатай мэргэжлийн чиглэлийг тогтоох, эмч, мэргэжилтнүүдийг сургах ажлыг зохион байгуулах;

4.1.21. эрүүл мэндийн салбар тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн системд шилжсэнтэй холбогдуулан гүйцэтгэлийн санхүүжилт, төлбөрт үйлчилгээнээс олсон орлогод нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын оруулсан хувь нэмрийг харгалзан тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

4.1.22. байгууллагаас гавьяаныхаа амралтад гарсан ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг холбогдох тэмдэглэлт өдрүүдтэй уялдуулан зохион байгуулж хэвших;

4.1.23. байгууллагын “Үйлдвэрчний эвлэлийн хороо”-той “Хамтын гэрээ” –ний үндсэн дээр хамтран ажиллах ба нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл боломжоор хангах;

#### **Тав. Эрүүл мэндийн төвийн зохион байгуулалтын бүтэц**

5.1. Төвийн зохион байгуулалтын бүтэцийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга батална.

5.2. Төв нь бүтцийн нэгж үйл ажиллагааны явц, үр дүнг Дүүргийн Засаг дарга болон Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын өмнө тайлагнана.

5.3. Төв нь хариуцсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж ажиллах бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөг Дүүргийн Засаг дарга, чиг үүргийн удирдлагын саналыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллана.

5.4. Төв нь Улсын Их хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, болон төрийн захиргааны төв байгууллагатай Дүүргийн Засаг даргаар дамжуулан харилцана.

5.5. Төв нь хууль тогтоомж, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг, даалгавар, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааны явц, үр дүнг тогтоосон хугацаанд Дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

### **Зургаа. Санхүүжилт**

6.1. Гүйцэтгэлийн санхүүжилтээр орж ирсэн төсөвт хөрөнгийг Дүүргийн санхүү, Төрийн сангийн хэлтсийн хяналт дор үр ашигтай зарцуулна.

6.2. Төвийн санхүүжилт нь Улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого, туслах үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

6.3. Төсвийг мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зарцуулна.

6.4. Хуульд заасны дагуу өмч, эд хөрөнгийг зохих журмын дагуу эзэмших, ашиглах, тайлан тооцоог цаг хугацаанд нь холбогдох дээд байгууллага, удирдлагад үнэн зөв гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

6.5. Төв нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ, хэлцэл байгуулан баталгаажуулан ажиллана. Ажил гүйцэтгэх гэрээ, хэлцэл хийх эрхийг даргын зөвшөөрөл олгосон эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

### **Долоо. Эрүүл мэндийн төвийн удирдлагын тогтолцоо**

7.1. Төвийн удирдлага нь дарга, Захиргаа, бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн орлогч дарга, Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга, Нийгмийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн орлогч даргаас бүрдэнэ. Эрүүл мэндийн төвийн даргыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Дүүргийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

7.2. Захиргаа хяналт, бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн орлогч дарга, Эмчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга, Нийгмийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн орлогч дарга, албадын дарга нар, салбар



амбулаториудын дарга, эрхлэгч болон эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдыг Эрүүл мэндийн төвийн дарга томилж, чөлөөлнө.

7.3. Эрүүл мэндийн төвийн удирдлагын тогтолцоо нь чиг үүргийн болон шугаман удирдлагатай хавсарсан хэлбэртэй байна.

7.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, цар хүрээ, үйл ажиллагааны гүйцэтгэл зэргийг харгалзан төвийн бүтэцийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулж, батлагдсан бүтэцэд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

7.5. Төвийн чиг үүрэгт хамаарах Дүүргийн хөгжлийн урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, батлуулах, салбар дундын уялдааг хангах, зохицуулах, хяналт тавих, захиргааны арга хэмжээний асуудлаар зөвлөмж, чиглэл өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн удирдлагыг Дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

7.6. Төвийн хариуцсан чиг үүргийн хүрээнд Дүүргийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллах, үйл явц, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах, Эрүүл мэндийн төвийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах шугаман удирдлагыг Эрүүл мэндийн төвийн дарга хэрэгжүүлнэ.

### **Найм. Эрүүл мэндийн төвийн даргын чиг үүрэг**

8.1. Төвийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.1.1. хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, төвийн “Хөдөлмөрийн дотоод журам”, холбогдох дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

8.1.2. батлагдсан бүтэцийн хүрээнд хууль, журмын дагуу албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт” -ыг боловсруулж, батлуулах, эмч, ажиллагсдыг томилох, чөлөөлөх, шаардлагатай тохиолдолд ажлын байр сэлгүүлэн ажиллуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

8.1.3. хүний нөөцийг зөв байршуулах, боловсон хүчний материаллаг баазыг бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг боловсронгуй болгох, ажлын уялдаа холбоог зохицуулах;

8.1.4. гүйцэтгэлээр орж ирсэн санхүүжилт, батлагдсан бүтэц, стандарт жишгийг баримтлан Эрүүл мэндийн төвийн дотоод нэгжийн бүтэц, зохион байгуулалтын зохицуулалт хийж, цалин, урамшуулал, нэмэгдэл олгох, нарийн мэргэжлийн буюу тусгай хэрэгцээт эмч, эмнэлгийн мэргэжилтний цалингийн жишгийг тогтоох;

8.1.5 Эрүүл мэндийн төвийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах;

8.1.6. Эрүүл мэндийн төвийг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

8.1.7. Захиргаа хяналт, бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн орлогч дарга, Эмчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга, Нийгмийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн орлогч дарга, албадын дарга нар, салбар амбулаториудын дарга, эрхлэгч болон эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсадтай “Хөдөлмөрийн гэрээ” байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг дүгнэх;

8.1.8. сахилга, дэг журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

8.1.9. эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг хууль тогтоомж, “Хөдөлмөрийн дотоод журам” -ын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, дотоод гадаадын сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулах;

8.1.10. эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авах;

8.1.11. хүн амын эрүүл мэндийг хамгаалахад идэвхи зүтгэл, санаачлага гаргасан, дэмжлэг тусалцаа үзүүлсэн төр захиргааны байгууллагын ажилтан, аж ахуйн нэгж, иргэд, идэвхитэн, тэргүүний ажилтай эмч, мэргэжилтнийг Төрийн болон Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн болон бусад шагналд тодорхойлох, шагнаж урамшуулах;

8.1.12. хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартад санал өгөх, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартыг мөрдүүлэх;

8.1.13. хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах дээд албан тушаалтанд хандаж санал гаргах, шийдвэрлүүлэх;

8.1.14. хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтан, холбогдох байгууллага, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах;

8.1.15. архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

8.1.16. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, иргэний төлөөлөлтэй хууль тогтоомжийн хүрээнд хамтарч ажиллах;



8.1.17. Эрүүл мэндийн төвийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, үйлчлүүлэгч, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

8.1.18. хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

8.2. Эрүүл мэндийн төвийн дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Удирдах зөвлөл байгуулан ажиллуулж болно.

8.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг төвийн дарга батална.

### **Ёс. Хариуцлага**

9.1. Албан ажилдаа хариуцлагагүй хандсаны улмаас бусдын хууль ёсны эрх ашгийг хохироосон, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон энэ дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Арав. Бусад зүйл**

10.1. Энэ дүрэмд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг байна.

10.2. Энэ дүрэм, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

---oOo---

